



БАТЛАВ
 ЗАСАГ ДАРГА Д.ГАЛХҮҮ
 2024 оны..... дугаар сарын.....

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН ИНЖЕНЕРИЙН
 ХИЙЦТЭЙ ХУДГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024.05.22

Алтан овоо

1	Ажил гүйцэтгэх үндэслэл	Цэнхэр сумын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ИТХ-ын 07 дугаар тогтоолд тусгагдсан.
2	Захиалагч:	Архангай аймгийн Цэнхэр сумын ЗДТГ.
3	Байршил	Цэнхэр сумын Цэцэрлэг баг, Алтан овоо баг, Буйлан баг , Цэнхэр багуудад гаргах 5-н худаг
3	Цооног өрөмдөх, цооногийг тоноглох, шавхалт	<ul style="list-style-type: none"> ➢ Цооногийн ашиглалтын ундарга: 2м3/цаг 6м3/цаг ус өгөх хүчин чадалтай байна. ➢ Суултын яндангийн материал нь ган, хуванцар хоолой байх ба ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн олон улсын чанарын гэрчилгээтэй байна. ➢ Шүүрийн яндангийн материал нь ган, хуванцар хоолой байх ба ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн олон улсын чанарын гэрчилгээтэй байна. ➢ Цооногоос ус өргөх яндангийн диаметр 32 мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO /хүйтний улиралд тэсвэртэй/ ➢ Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15 мм-ээс томгүй байна. ➢ Тунгаагуурын гүн: 2м-ээс багагүй ➢ Худгийг шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 24 цагаас багагүй ➢ Худгийн цооногийг түр хугацааны тагаар тоноглох ➢ Цохилтод өрмөөр өрөмдсөн тохиолдолд цооногийн нийт гүнд хамгаалалтын хуванцар хоолой хийнэ.
4	Худгийн усан сан, мал услах онгоц, талбай барих	<ul style="list-style-type: none"> - Худгийн байшингүй - Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь: 50мм диаметртэй, гаднах ханаас 2м урттай, худгийн шалнаас 60 см-ийн өндөрт гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргана. - Ундны ус авах хоолой нь: 50 мм диаметртэй, ган хоолойг цонхны доор гаргасан /ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох/ байна. - 40 мм-ийн диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд яг тохируулан тохиромжтой байрлалд гаргана. - Усан сан нь босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1.5м3-ээс багагүй багтаамжтай, ган усан сан байна. Усан сан нь

		дээгүүрээ модон тагтай, нөөцийн сангийн доод хэсэг нь шалнаас 20 см өндөртэй.
5	Мал услах онгоц	<ul style="list-style-type: none"> • Хэмжээ: 9м-ээс багагүй урттай байна. • Материал 400 мм-ийн голчтой, 1.5 мм-ийн зузаантай төмрөөр хагас цилиндр хэлбэртэй эсвэл цутгамал төмөр бетон /онгоцны дээд ирмэг газраас 50 см өндөр байна/ • Мал услах онгоцны доод хэсэг газраас 20 см байна • Онгоцыг худгийн барилгаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна. • Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхий гаргана. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эргэдэж хаадаг байхаар хийнэ. • Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулан гагнана. <p>Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна.</p>
6	Худгийн ус шахуурга, ус өргөх хоолой, шүүр яндан, цахилгаан үүсгүүр	<ul style="list-style-type: none"> • Худгийн ус шахуурга: ISO9001:2015 стандартын шаардлага хангасан байх • Ус шахуургын хөдөлгүүр нь олон улсын EN60335-1, 2012+A11 2014, AC:2014 стандартын шаардлага хангасан, 3 салаа цахилгааны утастай, утас нь ус шахуургын удирдлагын самбараар дамжин цахилгаанд холбогдоно. • Ус шахуурга нь 2019 онд үйлдвэрлэгдсэн байх/гарал үүслийн гэрчилгээ хавсаргах/ • Цахилгааны утас: IEC 60227-5 болон ISO 9001:2015 чанарын стандартын шаардлага хангасан. • VCTF эсвэл түүнтэй дүйцэхүйц загварын 3 салаатай, ус чийгнээс хамгаалагдсан давхар бүрээстэй, цооногт устай нөхцөлд ашиглах шаардлагыг хангасан байх, утас нь ус шахуургаас хянах самбар хүртэл залгаасгүй үргэлжилсэн байх. • Ус өргөх хоолой: • GB/T18997:1-2002 стандартын шаардлага хангасан, зориулалтын түүхий эдээр хийгдсэн, доод тал нь 1.0 МПас-с багагүй даралт даах чадвартай, цагаан өнгийн, дотор давхарга нь тунгалаг, ундны ус дамжуулах зориулалттай байх, Хоолойн гадна диаметр 32 мм-с багагүй байна. • Хянах самбар: Асаах унтраах товчлууртай, ус шахуурга ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах дохиололтой, цахилгаан үүсгүүр ажиллуулах асаагууртай. • Худгийн шүүр яндан: 100 м хүртэл гүнтэй цооног дахь шүүрийн яндангийн гадаад диаметр нь 127 мм-ээс доош байна. • Хуванцар хоолой нь анхдагч түүхий эд ашиглаж үйлдвэрлэсэн, MNS5544:2007 чанарын шаардлага хангасан, тохирлын гэрчилгээтэй байх, ундны усны

		<p>стандартын шаардлага хангасан, лабораторийн шинжилгээтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Эргэлтэт, цохилтот өрөмдлөгийн аргаар өрөмдсөн цооногт дахь шүүрийн янданд ус нэвтрүүлэх шүүрийг зориулалтын төхөөрөмжөөр хөндлөн байрлалаар нэг эгнээнд 8-10 ширхэг, 40-80 мм хэмжээтэй цуулбарлан ашиглаж болно. Хоолойн зузаан нь 3 мм-ээс багагүй байна. • Цахилгаан үүсгүүр: Бензинээр ажилладаг /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх
7	Санхүүжилт	- 100,000,0 гүйцэтгэлээр санхүүжилтийг олгоно -
8	Дээрхи ажлыг гүйцэтгэх хугацаа	- 2024.06.01 - 2024.08.01

ХЯНАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН: ХААТ-ИЙН
МЭРГЭЖИЛТЭН



Э.БОЛОРЦЭЦЭГ

Ч.УРАНЧИМЭГ